



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 11 дүгээр сарын 13
№42 /903/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол

1821

**Монгол Улсын шүүхийн тухай
хуулийн 17 дугаар зүйлийн
17.3.1 дэх заалт Үндсэн
хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх маргааныг
эцэслэн шийдвэрлэсэн тухай**



ГАРЧИГ

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

- | | | | |
|------|--|-----------|------|
| 482. | Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 07 | 1821 |
| 483. | Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 08 | 1831 |

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар
зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат /илтгэгч/, Т.Лхагваа, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Баясгалан, Г.Нацагдорж, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцлоо.



Хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 71 дүгээр тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн О.Баясгалан, Г.Нацагдорж нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулийн 17 дугаар зүйлд Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг хуульчлан заасан бөгөөд тус зүйлийн 17.3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд мөн зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;” гэж хуульчилсан байна.

Энэ нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж заасан ба Улсын дээд шүүхийг төлөөлөх эрхийг шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх иргэн, эрүү, захиргааны хэргийн дагнасан танхим эдлэхгүй байна. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд нийт шүүгчээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөн ажиллана гэж заагаад шийдвэрлэх асуудлыг хуульчилсан байна. Энэ заалтаас үзэхэд шүүгчдийн зөвлөгөөн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг шийдвэрлэхээр байна.

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтын “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэсэн заалтыг хэрхэн, яаж хэрэгжүүлэх тухай зохицуулалт Монгол Улсын шүүхийн тухай хуульд орхигдсон байна.



Үндсэн хуульд заасан “... бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэсэн заалт нь шүүхэд зориулагдсан заалт биш харин эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдэд зориулан заавал биелэх шинжтэй бөгөөд эрх зүйн хэм хэмжээний утга санааг шууд тайлбарлах эрхийг Улсын дээд шүүхэд олгосон байна. Улсын дээд шүүх нь эрх зүйн хэм хэмжээг бүтээх байгууллага биш учир дээрх эрхийг олгоод уг эрхээ эдлэхдээ алдаа гаргавал хэрхэн шийдвэрлэх тухай асуудлыг Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.” гэж заасан байгааг хууль тогтоогч анхаараагүй байна.

Мөн Үндсэн хуульд “... тайлбар гаргах;” гэж заасан нь бие даасан бичгэн баримт үйлдэх гэсэн утга бөгөөд хэрэг, маргаан хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоолыг хэлэхгүй юм.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин дараах агуулга бүхий тайлбарыг Үндсэн хуулийн цэцэн дунд суудлын хуралдаанд гаргасан байна. Үүнд:

“Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар Үндсэн хуулиас бусад хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхээс гаргах нь тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэсэн шүүхийн практикийг судлан дүгнэлт хийж, үүний үндсэн дээр бүх шатны шүүхээс хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцдаа хууль ёсны зарчим зөрчихгүй, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд чухал ач холбогдолтойгоос гадна Улсын дээд шүүхээс бусад шүүхэд үзүүлж буй мэргэжил, арга зүйн туслалцааны нэг хэлбэр мөн.

Монгол Улсын шүүхийн тухай 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хууль батлагдаж хүчин төгөлдөр болохоос өмнө хуулийн заалтыг тайлбарлуулах саналаа нэгдүгээрт, иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтын талаар, хоёрдугаарт, бүх шатны шүүх хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтын талаар талуудын гаргасан тайлбар, үндэслэлийн хамт Улсын дээд шүүхэд тус тус ирүүлж байв.



Ийнхүү дээр дурдсан журмаар ирүүлсэн саналын дагуу хуулийн тайлбарыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд оролцогчдын гуравны хоёрын саналаар батлан шийдвэрлэж байсан бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага заавал дагаж мөрддөг.

1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь Улсын дээд шүүхийн бүрэн эрхийн асуудал мөн. Өөрөөр хэлбэл хуулийн тайлбар бол аливаа хуулийн заалт буюу эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан харилцааг эрх зүйн ухамсар, хууль хэрэглээний үндсэн зарчим, зүй тогтолд тулгуурлан ийнхүү эрх зүйн актыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх зорилгоор түүний агуулгыг тодорхойлох үйл ажиллагаа билээ.

Улсын дээд шүүхээс гаргаж байсан албан ёсны тайлбар нь хэм хэмжээний ба жишгийн буюу казуаль хэлбэрийн аль алинд нь хамаардаг байв.

Улсын Их Хурлаас 2012 онд Монгол Улсын шүүхийн тухай хуулийг баталсан явдал шүүхийн институтыг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь боловсронгуй болгож дэлхий нийтийн жишигт хүргэх зорилтыг шийдвэрлэхэд тус дөхөм болно. Үүний дотор Улсын дээд шүүхээс хуулийн албан ёсны тайлбар гаргадаг асуудлыг илүү оновчтой болгох зорилгыг агуулсан юм. Учир нь хуулийн албан ёсны хэм хэмжээний тайлбар нь эрх зүйн хэм хэмжээний заалтын агуулгыг дэлгэрүүлж, хэм хэмжээний агуулгатай, нийтээр заавал дагаж мөрдөх шинжтэй тул хууль тогтоох ажиллагааг орлох боломжийг бүрдүүлж байна. Энэ асуудал Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж байсан Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр яригдаж байв.

Мөн Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." гэсэн зохицуулалт зөрчигдөж болзошгүй хэмээн үзэж Улсын дээд шүүхээс гаргадаг албан ёсны тайлбар жишгийн буюу казуаль шинжтэй байхаар хуульчилсан юм.

Мэдээлэл гаргагч нар Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах"-тай холбогдсон 4 дэх заалтыг хэрхэн яаж хэрэгжүүлэх тухай зохицуулалт орхигдсон, улмаар энэ нь "бие даасан бичгэн баримт үйлдэх" гэсэн утгатай байна гэжээ.

Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтын эрх зүйн үндэс, шүүхийн бүрэн эрхийг тогтоосон материаллаг хууль билээ. Иймд хуулийн албан ёсны тайлбар гаргах үйл ажиллагаатай



холбогдсон процессийн шинжтэй зохицуулалтыг дээр дурдсан хуульд тусгаагүй болно. Хуулийн тайлбарыг “Улсын дээд шүүхийн тогтоол” нэршилтэйгээр гаргаж байсан нь өмнө нь тогтоож ирсэн уламжлалтай салшгүй холбоотой билээ.

Харин 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өнөөдрийг хүртэл хугацаанд Улсын дээд шүүхээс аливаа хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгохоор албан ёсны тайлбар гараагүй байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

Гурав. Улсын дээд шүүхээс маргаантай холбогдуулан дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна. Үүнд:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах,” гэж заасны дагуу иргэд, хуулийн этгээдээс хуулийн зүйл, заалтыг тайлбарлуулахаар Улсын дээд шүүхэд хандаж байгаа бөгөөд энэ тохиолдолд шүүхээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтын хүрээнд хариу өгөхөөс өөрөөр шийдвэрлэх боломжгүй юм.

Түүнчлэн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ... Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэж тус тус зааснаас үзвэл энэ зүйлийн 17.3.1 дэх заалтыг хэрэглэхэд хүндрэл учирч болзошгүй, тухайлбал маргааны гол нь хяналтын шатны шүүхийн тогтоол /5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй/, эсхүл Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоолын алийг нь албан ёсны тайлбар гэж үзэх асуудлаар ойлгомжгүй байдал үүсч болохоор байна.” гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэц 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн дунд суудлын хуралдаанаараа энэхүү маргааныг хэлэлцэж 03 дугаар дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1. Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүх ямар замаар Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлахыг шууд заагаагүй боловч мөн



хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.” гэж заасан. Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүхийн шийдвэр ба Улсын дээд шүүхийн тайлбар хэмээх ойлголтыг томъёолж, улмаар Улсын дээд шүүхээс хэргийн болон хэм хэмжээний тайлбар гаргах тухай үзэл санааг илэрхийлсэн байна. Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад Улсын дээд шүүхээс зөвхөн хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэр шууд хуулийн албан ёсны тайлбар болохоор зохицуулсан нь энэ талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал хийгээд зохицуулалтад үл нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүхийн тайлбар нь хуулийн агуулгатай зөрчилдсөн бол тайлбарыг баримтлахгүйгээр зөвхөн хуулийг баримтлахаар заасан бөгөөд тухайн тайлбараар хуулиас давсан хэм хэмжээ бий болгохгүй тул Улсын дээд шүүхээс хуулийн хэм хэмжээний тайлбар гаргах нь хууль тогтоох эрх мэдэлд халдана гэж үзэх үндэслэлгүй юм.

2. Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилсан тохиолдолд Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох тухай Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар хэрхэн хэрэгжүүлэх талаарх зохицуулалт орхигдсон байна. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг хэрхэн хуулийн нэг мөр, албан ёсны тайлбар болгох журмыг тусгайлан зохицуулаагүйгээс үүдэн уг хуулийн холбогдох зохицуулалтын дагуу Улсын дээд шүүхийн аль нэг танхимаас гаргасан шийдвэр бүр хуулийн тайлбар болох нөхцөл бүрдэн, агуулгын хувьд зөрчилдсөн шийдвэр гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй болж, Улсын дээд шүүхийн 3-5 шүүгчийн саналаар хуульд тайлбар хийх боломжийг бүрдүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.” гэжээ.

Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:

“1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны



тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.” гэжээ.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээр дурдсан дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр хэлэлцээд “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 71 дүгээр тогтоол гаргасан байна. Уг тогтоолд:

“1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэжээ.

Зургаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Нэг. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийг 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр хэлэлцээд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх



Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 71 дүгээр тогтоолыг баталсан.

Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь Улсын дээд шүүхийн бүрэн эрхийн асуудал юм. Хуулийн тайлбар бол аливаа хуулийн заалт буюу эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан харилцааг эрх зүйн ухамсар, хууль хэрэглээний үндсэн зарчим, зүй тогтолд тулгуурлан ийнхүү эрх зүйн актыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх зорилгоор түүний агуулгыг тодорхойлох үйл ажиллагаа юм. Улсын дээд шүүхээс өмнө нь гаргаж байсан албан ёсны тайлбар нь хэм хэмжээний ба жишгийн буюу казуаль хэлбэрийн аль алинд нь хамаардаг байв.

Улсын Их Хурлаас 2012 онд Монгол Улсын шүүхийн тухай хуулийг баталсан явдал нь шүүхийн институтыг бэхжүүлэх, үйл ажиллагааг боловсронгуй болгох, дэлхий нийтийн жишигт хүргэсэн алхам болсон. Ингэснээр Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэсэн зохицуулалтыг улам бататгаж Улсын дээд шүүхээс гаргадаг албан ёсны тайлбар нь жишгийн казуаль шинжтэй байхаар хуульчилж өгсөн юм.

Энэ талаар хийгдсэн судалгаанаас авч үзэхэд дэлхийн улс орнуудад дээд шүүх нь абстракт маягийн өөрийн санаачилгаар тайлбар хийдэг улс орон пост коммунист орнууд л байсан ба одоо Казахстан зэрэг цөөхөн улс үлдсэн бөгөөд бусад орнуудад дээд шүүх нь ингэж тайлбар хийхийг хориглодог байна.

Харин дээд шүүх, Үндсэн хуулийн шүүх хоёр нь нэг байгаа улсуудад бол төрийн болон хууль хэрэгжүүлэх байгууллагуудын хүсэлтээр дээд шүүх нь тайлбар гаргадаг жишиг байдаг бөгөөд манай улсын хувьд 1960 оноос хойш Улсын дээд шүүхийн гаргасан тайлбаруудыг судлахад 80 гаруй хувь нь Улсын дээд шүүх өөрийн санаачлагаар тайлбар гаргасан байна.

Дээд шүүх яагаад ийм абстракт тайлбар гаргаж болдоггүй вэ гэвэл нэгдүгээрт, шүүх нь иргэний буюу эрх ашиг нь хөндөгдсөн хэн нэгэн хүний гомдлоор шүүн таслах үйл ажиллагаа явуулдаг болохоос шүүх өөрийн идэвх санаачлагаар ийм шийдвэр гаргахыг хориглодог. Учир нь шүүх гэдэг утгаа алдахад хүрнэ. Хоёрдугаарт, Дээд шүүхийн хууль тайлбарлаж байгаа нь эрх зүйн маргаан байдаг учраас дээд шүүх хяналтаа хэрэгжүүлэхдээ эрх зүйн маргааныг шийдвэрлэх явцдаа тайлбар гаргадаг чиг үүргээсээ тусдаа хууль тайлбарлах гэдэг байдлаар чиг үүрэг авч болохгүй гэж үздэг байна. Гуравдугаарт, Дээд шүүх хэрэв абстракт тайлбар гаргаж байгаа тохиолдолд хариуцлагыг нь хэн хүлээх вэ гэсэн асуудал тавигддаг.



Дээд шүүх нь шүүхийн нэгдсэн практик тогтоох зорилготойгоор тайлбар гаргах ёстой. Түүнээс хууль тогтоогч шиг бүх субъектэд үйлчлэх хэм хэмжээг тайлбарлах ёсгүй юм. Хууль хэрэглэх, хууль хэрэгжүүлэх, хууль тогтоох гэдэг бол хоорондоо зааг ялгаатай хуваарилагдсан ойлголт учир Улсын дээд шүүхээс Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх замаар гаргаж байгаа нь Үндсэн хуулийг зөрчөөгүй болно.

Хууль тогтоогчид нь хуулиа илүү тодорхой, нарийвчилсан байдлаар гаргаж, Дээд шүүх нь уг хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгон хэрэглэхэд чиглэсэн тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар гаргах нь Үндсэн хуулийн уг үзэл санааг зөв ойлгон хэрэгжүүлэхэд бүрнээ нийцэж байгаа тул Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс энэ асуудлыг анхааран үзэж шийдвэрлэхийг хүсэж байна” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг хууль тогтоогч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад хуульчлахдаа Улсын дээд шүүх зөвхөн тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргана гэсэн нь анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд хуулийг нэг мөр, зөв хэрэглэхтэй холбоотой асуудлаар гарсан саналыг үндэслэн тайлбар гаргах Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг явцууруулан хязгаарласан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тайлбар гэсэн ойлголтыг тусад нь томъёолон хуульчилсан байх тул Улсын дээд шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргасан шийдвэр нь шууд хуулийн албан ёсны тайлбар болохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болон зохицуулалтад харшилж байна.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг хэрхэн албан ёсны тайлбар болгох журмыг тусгайлан зохицуулаагүйгээс үүдэн уг хуулийн холбогдох зохицуулалтын дагуу Улсын дээд шүүхийн аль нэг танхимаас гаргасан шийдвэр бүр хуулийн тайлбар болох нөхцөл бүрдэн, агуулгын хувьд зөрчилдсөн шийдвэр гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй болж, Улсын дээд шүүхийн 3-5 шүүгчийн саналаар хуульд тайлбар хийх боломжийг бүрдүүлсэн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.



3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 71 дүгээр тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар дүгнэлтийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 71 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН

П.ОЧИРБАТ

Т.ЛХАГВАА

Д.СУГАР

Д.НАРАНЧИМЭГ

Д.СОЛОНГО

Д.ГАНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон
Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж,
эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Т.Лхагваа, Д.Сугар, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Батцэнгэл, түүний өмгөөлөгч С.Үлэмж, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцов. Мэдээлэл гаргагч, иргэн Б.Билгүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.2, 65.3, 65.4; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 56 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд оршин суугч, иргэн Б.Батцэнгэл, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 6 дугаар багийн оршин суугч, иргэн Б.Билгүүн нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдаж 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс дагаж мөрдөж байгаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх



хэсэгт зааснаар “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл, шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.”, мөн зүйлийн 65.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 хэсэгт “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.”; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр оруулсан “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэсэн нэмэлт, өөрчлөлтөд зааснаар хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо нь анхан шатны шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй мэт ойлгогдохоор байна.

Аливаа хүн өөрийн эрх ашгаа хамгаалуулахаар бүх шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байх нөхцөлийг төрийн зүгээс бүрдүүлэх нь төрөөс иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах эрх, эрх чөлөөний баталгаа байхаас гадна шүүхийн шударга ёсны илэрхийлэл болдог. Ингэхдээ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт зааснаар “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.” гэж заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн этгээд нь шүүхийн дэс дараалсан шатлалтайгаар эрхээ хамгаалуулах боломжтой байна. Гэтэл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн холбогдох хэсэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” 2 дахь хэсэгт “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” 3 дахь хэсэгт “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.” гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. ...” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэгд гаргасан тайлбартаа:

“1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй”, 65.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана”, 65.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана”, 65.4 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ”; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, хуулиас гадуур шүүх байгуулах агуулгыг илэрхийлээгүй бөгөөд Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд гомдлыг хэрхэн шүүхэд гаргахтай холбоотой үйл явцыг зохицуулж хуульчилсан байна. Иймд эдгээр заалт нь Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

2. Нэр бүхий иргэдийн мэдээллийн гол зорилго нь “Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороог анхан шатны шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй мэт ойлгогдохоор байна” гэсэн өгүүлбэрээр илэрхийлэгдэж байна гэж ойлгож байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дурдсан заалт бус Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэх заалтын тайлбар нь тус маргааны агуулгад хамаарах заалт юм. Эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсч болох аливаа маргааныг таслан шийдвэрлэх ажиллагааг улс орнуудын хууль тогтоогчоос тухайн харилцааны онцлог шинж, маргааны талууд, мөн үр ашигтай байдлыг харгалзан арбитр, эвлэрүүлэн зуучлал, маргаан таслах комисс, сахилга, ёс зүйн хороо гэх мэт маргаан шийдвэрлэх тусгай этгээдүүдэд хуваарилан харьяалуулах нь хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн арга хэрэгсэл бөгөөд



тэр болгоныг шүүх эрх мэдлийг хуулиас гадуур хэрэгжүүлж байна гэж үздэггүй билээ. Хууль тогтоогчоос эдгээр маргаан таслах этгээдүүдийн үйл ажиллагааг талуудын процессын шинжтэй эрх, маргаан шийдвэрлэх ажиллагааны шударга, төвийг сахисан байдлыг хангах зорилгоор нарийвчлан зохицуулж, гаргасан шийдвэрийг шүүхийн шийдвэрийн нэгэн адил үзэж заавал биелүүлэх, мөн хуульд заасан үндэслэлээр дахин хянан үзэх тогтолцоог бий болгосон байдаг. Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд ч энэ төрлийн маргаан шийдвэрлэх бусад арга хэрэгслийг ашигласан тохиолдол цөөнгүй бий.

Мэргэжлийн хариуцлагын хороо нь нийтийн эрх зүйн этгээд хувьдаа захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарах бөгөөд бусад нийтийн захиргааны этгээдтэй харьцуулбал хуульч мэргэжилтнүүд, тэр дундаа шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааны талаарх гомдол шийдвэрлэдэг, маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнд нь мэргэжлийн хуульчид буюу шүүгч, өмгөөлөгч, прокурорууд ордгоороо онцлогтой. Хууль тогтоогчоос тус онцлогийг харгалзан Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, цаашлаад Улсын дээд шүүхэд хянаж үзэхээр зохицуулжээ. Ийнхүү тус ажиллагаа нь шүүхийн хяналтад байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх”-ээр зохицуулсан нь эрх зүйн бүх маргаан эдгээр шүүхийн дэс дараалсан шатлалаар маргаанаа шийдвэрлүүлнэ гэж ойлгогдохгүй юм. Тодорхой маргааныг онцлог шинж, ач холбогдлоос нь хамааран гурван эрэмбийн шүүхийн алинд ч авч хэлэлцэх тодорхой тохиолдлууд байх нь өнөөгийн дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоонд нийтлэг Монгол Улсын Үндсэн хуульд /тухайлбал Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэг дэх Улсын дээд шүүхийн бүрэн эрх/ ч тусгалаа олсон үзэл баримтлал юм. Энэ үзэл баримтлалын хүрээнд хууль тогтоогчоос Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийг бүхэлд нь харвал хууль тогтоогчоос захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо нь ямар төрлийн маргааныг аль шатны шүүхэд хянан шийдвэрлэх харьяаллыг хуваарилан зохицуулсан байна.

Хуульчдын мэргэжлийн хариуцлагатай холбогдох маргааныг ийнхүү ердийн маргаанаас өөр журмаар зохицуулах нь нийтлэг бөгөөд тухайлбал Европын улсуудад хуульчдийн мэргэжлийн өөрийн удирдлагын байгууллага өөрөө хуульчдын эсрэг мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүй сахилгын хэргийг авч үзэх тусгай бүтэц /хороо, трибунал гэх мэт/-тэй бөгөөд түүний шийдвэрийг давж заалдах эрхийг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- Чех, Грек, Испани, Португал, Их Британи, Норвеги, Словени зэрэг улсууд Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагын дотооддоо давах шатны трибунал /хороогоор шийдвэрлэн ердийн шүүхэд хандах эрхгүйгээр;
- Дани, Финланд, Франц, Унгар, Итали, Лихтенштейн зэрэг улсуудад Давах шатны шүүхэд /appeal courts/;
- Исланд, Швед, Словак зэрэг улсуудад шууд улсын Дээд шүүхэд хандаж хянуулах эрх олгосон байна.

Харин ХБНГУ, Австри, Нидерланд, Польш зэрэг улсуудад шат шатны шүүхийн дэргэдэх хуульчийн ёс зүйн тусгай трибуналаар /өмгөөлөгчид ба шүүгчдээс бүрддэг/ ийм төрлийн маргааныг шийдвэрлэдэг байна. Америкийн Нэгдсэн Улсын хувьд тус асуудал нь мужийн асуудал бөгөөд мужуудад эхлээд Барын холбоодын тусгайлсан маргаан шийдвэрлэх хороогоор, түүний шийдвэрийг мужийн Дээд шүүхүүдэд шууд харьяалуулан шийдвэрлэх нь нийтлэг байдаг.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль нь эдгээр жишгийг судалсны үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд тус маргааныг харьяалуулсан болно.

Дээр дурдсаныг үндэслэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-65.4 дэх хэсэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх явцад Монголын хуульчдын холбооноос 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2/347 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарт:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад зааснаар Монгол Улсын иргэн нь “... хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...” эрхтэй бөгөөд иргэний уг эрх мөн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч “шүүх”-ээр дамжин хэрэгжих учиртай.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлд Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэртэй холбогдуулан шүүхэд гомдол гаргахтай холбогдсон харилцааг зохицуулсан боловч хуулийн 65.1 дэх хэсэгт гомдлыг шууд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргахаар заасан.



Хуулийн уг зохицуулалттай холбоотойгоор Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг өөрчлөн найруулж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан иргэн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан гэдэгтэй санал нэг байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхийн тогтолцоо нь нутаг дэвсгэрийн нэгжээр байгуулагдахаар тогтоож, мөн зүйлийн 2 дахь хэсэгт шүүхийн зохион байгуулалт эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор заасан.

Үндсэн хуулийн энэхүү зохицуулалтыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд тодруулан зохицуулсан ба 10.1 дэх хэсэгт шүүхийн тогтолцоо нь хяналтын шатны шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхээс бүрдэхээр заасан.

Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 20.1.1 дэх заалтад “анхан шатны шүүхийн шийдвэрийг ... давж заалдах журмаар хянан шийдвэрлэх; 20.1.2 дахь заалтад “хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;”-ээр эрх олгосон.

Харин шүүхийн бус байгууллагын гаргасан шийдвэрийг шууд давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэх эрхийг хуулиар олгоогүй байхад шүүхийн зохион байгуулалтын эрх зүйн үндэслэлийг тодорхойлдоггүй өөр хуулиудад шүүхийн бус байгууллагын шийдвэрийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан нь буруу юм.

Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах, гомдлыг хүлээн авах, давж заалдах шатны шүүхэд хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн зохицуулалт, уг шийдвэрийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх тухай Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, 2 дахь заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа.

3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан Мэргэжлийн хариуцлагын хороо нь шүүх биш бөгөөд шүүхийн эрх хэмжээг эдэлдэггүй.



Иймээс Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн холбогдох хэсэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ..., Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг зөрчсөн гэх мэдээлэл гаргагч нарын тайлбар үндэслэлгүй гэж үзэж байна.

4. Монгол Улсын Хууль зүйн сайдын 2015 оны А/03 дугаар тушаалаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан хуулийн төслийг бэлэн болгож, холбогдох байгууллагын саналыг авах ажиллагаа явагдах гэж байгаа болно.

Нэр бүхий иргэдийн мэдээлэлд дурдсан асуудлыг Хуульчдын холбоо урьд нь анхааралтай судлан үзэж байсан ба Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах явцад Хуульчдын холбооны зүгээс гаргасан саналын дагуу иргэний шүүхэд гомдол гаргах үндсэн эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэртэй холбогдсон гомдлыг Захиргааны хэргийн шүүхэд ердийн журмаар гаргадаг байхаар төсөлд тодорхой тусгасан байгаа болно.” гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 09 дүгээр дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:

“1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргахаар, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт уг давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхээр заасан байна.

Түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2, 65.3, 65.4 дэх хэсэгт давж заалдах гомдлыг хүлээн авах, давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх зэргээр анхан шатны шүүхийн гүйцэтгэх үүргийг Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо гүйцэтгэхээр тогтоосон гэж үзэхээр байна.



Мөн Монголын хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хурлын 86 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 1.9 дүгээр зүйлийн 1-д “Хуульч нь зөрчил гаргасан эсэх, эсхүл мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрх мэдлийг хороо хэрэгжүүлнэ.” гэсэн байна.

Ингэснээрээ дээрх хуулийн зохицуулалт Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хорооноос гаргасан шийдвэр анхан шатны журмаар маргааныг шийдвэрлэсэн шийдвэрт тооцогдох, шүүхийн бус байгууллагаас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглох үндсэн зарчмыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.2, 65.3, 65.4, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.2, 65.3, 65.4, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.” гээд

Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:

“1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.” гэж заасны “гомдол гаргах” гэсний өмнөх “... давж заалдах ...” гэсэн хэсэг, 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж



заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.” гэсэн нь; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж заасны “... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.”, 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.”; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.” гэснийг зөрчөөгүй байна.

3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс



зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.” гэж заасны “гомдол гаргах” гэсний өмнөх “... давж заалдах ...” гэсэн хэсгийг; 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.” гэснийг; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж заасны “... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2015 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Тав. Монгол Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай” 56 дугаар тогтоолд:

“1.“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.” гэж заасны “гомдол гаргах” гэсний өмнөх “... давж заалдах ...” гэсэн хэсэг, 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан



тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.” гэсэн нь; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж заасны “... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

Зургаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Улсын Их Хурлын гишүүн миний бие Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-65.4 дэх хэсэг болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэх гэж байгаатай холбогдуулан дараах нэмэлт тайлбарыг гаргаж байна.

Нэг. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-65.4 дэх хэсэг болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзлээ.

Хоёр. Эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсч болох аливаа маргааныг таслан шийдвэрлэх ажиллагааг улс орнуудын хууль тогтоогчоос тухайн харилцааны онцлог шинж, маргааны талууд, мөн үр ашигтай байдлыг харгалзан арбитр, эвлэрүүлэн зуучлал, маргаан таслах комисс, сахилга, ёс зүйн хороо гэх мэт маргаан шийдвэрлэх тусгай этгээдүүдэд хуваарилан харьяалуулах нь хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн арга хэрэгсэл бөгөөд үүнийг шүүх эрх мэдлээс гадуур хэрэгжүүлж байна гэж үздэггүй билээ.



Хууль тогтоогчоос эдгээр маргаан шийдвэрлэх ажиллагааны шударга, төвийг сахисан байдлыг хангах зорилгоор нарийвчлан зохицуулж, гаргасан шийдвэрийг шүүхийн шийдвэрийн нэгэн адил үзэж заавал биелүүлэх, мөн хуульд заасан үндэслэлээр дахин хянан үзэх тогтолцоог бий болгосон байдаг. Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд ч энэ төрлийн маргаан шийдвэрлэх бусад арга хэрэгслийг ашигласан тохиолдол цөөнгүй байдаг.

Мэргэжлийн хариуцлагын хороо нь нийтийн эрх зүйн этгээдийн хувьд захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарах бөгөөд бусад нийтийн захиргааны этгээдтэй харьцуулбал хуульч мэргэжилтнүүд, тэр дундаа шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааны талаарх гомдол шийдвэрлэдэг, маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнд нь мэргэжлийн хуульчид буюу шүүгч, өмгөөлөгч, прокурорууд багтдагаараа онцлогтой юм. Хууль тогтоогчоос тус онцлогийг харгалзан Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, цаашлаад Улсын дээд шүүхэд хянаж үзэхээр зохицуулжээ. Ийнхүү тус ажиллагаа нь шүүхийн хяналтад байна.

Бусад улс орнуудад хуульчдын мэргэжлийн хариуцлагатай холбоотой маргааныг ердийн маргаанаас өөр журмаар зохицуулах нь нийтлэг байдаг. Тодруулбал, Европын улсуудад Хуульчдын мэргэжлийн өөрийн удирдлагын байгууллага өөрөө хуульчдын эсрэг мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүйн сахилгын хэргийг авч үзэх тусгай бүтэц /хороо, трибунал гэх мэт/-тэй байна. Тухайлбал, Чех, Грек, Испани, Португал, Их Британи, Норвеги, Словени зэрэг улсууд Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагын дотооддоо давах шатны трибунал хороогоор шийдвэрлэн ердийн шүүхэд хандах эрхгүй байдаг бол Дани, Финланд, Франц, Унгар, Итали, Лихтенштейн зэрэг улсуудад Давах шатны шүүхэд, Исланд, Швед, Словак зэрэг улсуудад шууд улсын Дээд шүүхэд хандаж хянуулах эрх олгосон байна. Харин ХБНГУ, Австри, Нидерланд, Польш зэрэг улсуудад шат шатны шүүхийн дэргэдэх хуульчийн ёс зүйн тусгай трибуналаар /өмгөөлөгчид ба шүүгчдээс бүрддэг/ ийм төрлийн маргааныг шийдвэрлэдэг байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль нь эдгээр жишгийг судалсны үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд тус маргааныг харьяалуулсан болно.

Дээрх саналуудыг анхааран үзэхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсч байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.2, 65.3, 65.4 дэх хэсэгт Хуульчийн мэргэжлийн хариуцлагын



хорооны шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах, давж заалдах гомдлыг хүлээн авах, талуудын тайлбар болон холбогдох бусад баримт сэлтийг бүрдүүлж давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх зэргээр анхан шатны шүүхийн гүйцэтгэх үүргийг Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороо гүйцэтгэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт уг давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхээр тус тус зохицуулсан нь Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хорооноос гаргасан шийдвэр анхан шатны журмаар маргааныг шийдвэрлэсэн шийдвэрт тооцогдох, шүүх эрх мэдлийг шүүх бус өөр байгууллага хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай” 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 56 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ТОГТООХ НЬ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.” гэж заасны “гомдол гаргах” гэсний өмнөх “... давж заалдах ...” гэсэн хэсэг, 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын



албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.” гэсэн нь; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж заасны “... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай” 56 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД

Н.ЖАНЦАН
П.ОЧИРБАТ
Т.ЛХАГВАА
Д.СУГАР
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 14003